



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/147

Зуунмод

Дайчилгаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.13, 10 дугаар зүйлийн 10.4.4, 19 дүгээр зүйлийн 19.1, 32 дугаар зүйлийн 32.1.9, Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Дайчилгаа зохион байгуулах журам”-ын 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод суманд Коронавируст халдварын тохиолдол илэрсэнтэй холбогдуулан Арга билэг сувилал, Аржанчивлан рашаан сувилал, Зуунмод суман дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байр, Хүмүүн цогцолбор ахлах сургуулийн дотуур байруудыг халдвар илэрсэн иргэдийн ойрын болон дам хавьтлыг тусгаарлах зорилгоор дайчилсугай.

2. Тусгаарлан ажиглах байрны үйлчилгээний зардлыг нэгдүгээр, хоол хүнсний зардлыг хоёрдугаар, ахуйн хэрэглэгдэхүүний зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга билэг сувилал, Аржанчивлан рашаан сувилал, Зуунмод суман дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Хүмүүн цогцолбор ахлах сургуулийн захирал, дарга, эрхлэгч нар тусгаарлагдах иргэдийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх, байрны бэлэн байдлыг хангаж ажиллахыг даалгасугай.

4. Тусгаарлан ажиглах байрны халдвар хамгаалал, бэлэн байдалд үзлэг шалгалт хийж, заавар зөвлөмж өгч ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг/-т үүрэг болгосугай.

5. Шаардагдах зардал 23,330,778 (хорин гурван сая гурван зуун гучин мянга долоон зуун далан найм) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс гаргахыг Санхүү, төрийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д зөвшөөрсүгэй.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ц.Буманбуян)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР